



МОНГОЛЫН  
ХУУЛЬЧДЫН  
ХОЛБОО



ПРОКУРОРЫН  
ХОРОО



МОНГОЛЫН  
НОТАРИАТЧДЫН  
ТАНХИМ

# ХУУЛЬЧДЫН СПОРТЫН НААДАМ-2026

## 7 ТӨРӨЛТ ТЭМЦЭЭН

### МОНГОЛЫН ХУУЛЬЧДЫН ХОЛБООНЫ “ХУУЛЬЧДЫН СПОРТЫН НААДАМ-2026” ШИЛЖИН ЯВАХ ЦОМЫН ТӨЛӨӨХ СПОРТЫН ТЭМЦЭЭНИЙ УДИРДАМЖ

2026 оны 04 дүгээр сарын 14-ний өдөр

Улаанбаатар хот

Монголын Хуульчдын Холбооны Зөвлөл, Чиг үүргийн болон Сайн дурын хороод, Тамгын газар, орон нутгийн салбарын гишүүдийн дунд спортын 7 төрлөөр “Шилжин явах цом”-ын төлөөх тэмцээнийг 2026 оны 05 дугаар сарын 18-ны өдрөөс 23-ны өдрүүдэд зохион байгуулна.

#### НЭГ. ТЭМЦЭЭНИЙ ЗОРИЛГО

- 1.1. Хуульчдын дунд чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх, биеийн тамир, спортоор хичээллэх, идэвхтэй хөдөлгөөн, эрүүл мэндийг дэмжих, спортын талбарт шударгаар өрсөлдөх, мэргэжил нэгт нөхөдтэйгөө танилцахад оршино.

#### ХОЁР.ТЭМЦЭЭНИЙ ТӨРЛҮҮД

- 2.1 Тэмцээнийг дараах төрлөөр зохион байгуулна.
  - 2.1.1 Усанд сэлэлт (эрэгтэй 1, эмэгтэй 1)
  - 2.1.2. Дартс (эрэгтэй 3, эмэгтэй 2 тамирчнаас бүрдсэн холимог багаас бүрдэх ба багийн нэг гишүүнд хорооны дарга заавал оролцоно)
  - 2.1.3. Боулинг (эрэгтэй 3, эмэгтэй 2 тамирчнаас бүрдсэн холимог баг)
  - 2.1.4. Биллиард (эрэгтэй 1, эмэгтэй 1)
  - 2.1.5. Ширээний теннис (эрэгтэй 1, эмэгтэй 1)
  - 2.1.6. Волейбол (эрэгтэй, эмэгтэй тус бүр 9 тамирчнаас бүрдсэн баг)
  - 2.1.7. Сагсан бөмбөг (эрэгтэй, эмэгтэй тус бүр 8 тамирчнаас бүрдсэн баг)

#### ГУРАВ. ТЭМЦЭЭН ЗОХИОН БАЙГУУЛАХ ЖУРАМ

##### 3.1.Усанд сэлэлт

- 3.1.1. Тэмцээнийг мэлхий, өврөөр даллах сэлэлтийн төрлөөр явуулна.
- 3.1.2. Тамирчид мэлхий, өврөөр даллах сэлэлтийн төрлөөр тус бүр 50 метр зайд сэлнэ.
- 3.1.3. Тамирчид мэлхий, өврөөр даллах сэлэлтийн техникийн буруу гүйцэтгэсэн тохиолдолд тэмцээний шүүгч гүйцэтгэлийн цагт 10 секунд нэмэх торгууль оногдуулна.
- 3.1.4. Мэлхий, өврөөр даллах сэлэлтийн төрлөөр тус бүрийн цагийн нийлбэрийг нэмж, аль бага цаг зарцуулснаар нь ялагчийг шалгаруулна.

##### 3.2.Дартс

- 3.2.1. Дартсын тэмцээнд оролцох 1 гишүүн нь заавал хорооны тэргүүн байна.
- 3.2.2. Тэмцээнд оролцох багууд сугалаа сугалах журмаар 3 хэсэгт хуваагдана.
- 3.2.3. Хэсэгт хуваагдсан багууд дотроо тойргоор тоглож, хожлоороо шалгарсан эхний 2 баг дараагийн шатанд шалгарна. (Хэсгийн 1, 2-р байрыг шалгаруулахад хожил тэнцсэн тохиолдолд аль нэгнийгээ хожсон баг нь 1-ээр шалгарна. 3 баг бие биеэ тойрч хожин, нийт хожлын тоо тэнцсэн тохиолдолд тэдгээр багуудын хоорондын тоглолтын хожигдсон үеийг тоолж, аль цөөн үе хожигдсон “Контр гаргаагүй” баг шалгарна)
- 3.2.4. Тоглолтын үе (контр) тэнцвэл тухайн багуудын хоорондын тоглолтын нийт авсан онооны нийлбэрийг нэмж аль их оноогоор хожсон баг дараагийн шатанд шалгарна.
- 3.2.5. Хэсгээс шалгарсан багууд дахин бүсэд хуваагдан тоглож, бүс тус бүрээс 2 баг хагас шигшээд шалгарна.

- 3.2.6. Хагас шигшээд шалгарсан 4 багаас бүсээсээ 1-ээр гарсан баг нөгөө бүсээс 2-оор гарсан багтай зөрж хоорондоо тоглож хожсон 2 баг алт, мөнгөн медалийн төлөө, хожигдсон 2 баг хүрэл медалийн төлөө тоглоно.
- 3.2.7. Өрсөлдөж буй 2 багийн 57 сумын шидэлтийн тоо гүйцэж, оноо тэглээгүй тохиолдолд багийн ахлагч "Бухын нүд"-нд шидэж, төвийн цэгт хамгийн ойр оносон нь хожно.
- 3.2.8. Шигшээ тоглолтуудад сумны тоо хязгааргүй буюу 0 оноонд хүрэх сүүлийн сумаа заавал бухын нүд, эсвэл 2 дахин үржүүлж авах нарийн хэсэгт онож дуусгана.

### **3.3. Боулинг**

- 3.3.1. Тэмцээнд оролцох багууд сугалаа сугалах журмаар 3 хэсэгт хуваагдана.
- 3.3.2. Тэмцээнийг зохион байгуулагчдаас томилогдсон шүүгч шүүнэ.
- 3.3.3. Шидэлтийн үед пин дутуу тавигдсан, пин унаж хэвтээ байрлалтай болсон тохиолдолд шүүгчид заавал мэдэгдэх бөгөөд пин гүйцэд тавигдсаны дараа шидэлтийг хийнэ. Шүүгчид мэдэгдэлгүйгээр шидсэн тохиолдолд тухайн оноог хасаж тооцно.
- 3.3.4. Тэмцээн 2 үе шаттай явагдах бөгөөд эхний шатаас хамгийн өндөр оноо авсан 4 баг шигшээ тоглолтод оролцох эрхээ авах бөгөөд хоёрдугаар шатанд оролцох багуудын эхний шатанд авсан оноо шигшээ тоглолтод нөлөөлөхгүй.

### **3.4. Биллиард**

- 3.4.1. Тэмцээнд оролцох тамирчид сугалаа сугалах журмаар 3 хэсэгт хуваагдана.
- 3.4.2. Тамирчид хэсэг дотроо тойргоор тоглож, хожлоороо шалгарсан эхний 2 тамирчныг хэсгээс 1, 2-р байраар шалгаруулна. Хэсгийн 1, 2-р байрыг шалгаруулахад хожил тэнцсэн тохиолдолд аль нэгнийгээ хожсон тамирчин нь 1-ээр шалгарна. 3 тамирчин бие биеэ тойрч хожин нийт хожлын тоо тэнцсэн тохиолдолд зөвхөн хожил нь тэнцсэн багуудын хоорондоо тоглосон тоглолтын онооны харьцаануудыг нэмж, хамгийн их нэмэх оноотой тамирчныг шалгаруулна.
- 3.4.3. Хэсгээс шалгарсан тамирчид дахин бүсэд хуваагдан тоглож, бүс тус бүрээс 2 тамирчин хагас шигшээд шалгарна.
- 3.4.4. Хагас шигшээд шалгарсан 4 тамирчнаас бүсээсээ 1-ээр гарсан тамирчин нөгөө бүсээс 2-оор гарсан тамирчинтай зөрж хоорондоо тоглож хожсон 2 тамирчин алт, мөнгөн медалийн төлөө, хожигдсон 2 тамирчин хүрэл медалийн төлөө тоглоно.
- 3.4.5. Тоглолт эрэгтэй 6, эмэгтэй 3 улаан бөмбөгөөр снукер биллиардын дүрмээр явагдана. Шигшээ тоглолтууд эрэгтэй тамирчид 15 улаан бөмбөгөөр, эмэгтэй тамирчид 6 улаан бөмбөгөөр тоглоно.

### **3.5. Ширээний теннис**

- 3.5.1. Тэмцээнд оролцох тамирчид сугалаа сугалах журмаар 3 хэсэгт хуваагдана.
- 3.5.2. Хэсэгт хуваагдсан тамирчид тойргоор тоглож, хожлоороо шалгарсан эхний 2 тамирчин шалгарна.
- 3.5.3. Хэсгийн 1, 2 дугаар байрыг шалгаруулахад хожил тэнцсэн тохиолдолд аль нэгнийгээ хожсон тамирчин 1-р шалгарна.
- 3.5.4. Тамирчин бие биеэ тойрч хожсон тохиолдолд тамирчдын хожигдсон үеийг тоолж, аль цөөн үе хожигдсон (Контр гаргаагүй) тамирчин цааш шалгарна.
- 3.5.5. Хэсгээс шалгарсан тамирчин дахин бүсэд хуваагдан тоглож, бүс тус бүрээс 2 тамирчин хагас шигшээд шалгарна.
- 3.5.6. Хагас шигшээд шалгарсан 4 тамирчнаас бүсээсээ 1-ээр гарсан тамирчин нөгөө бүсээс 2-оор гарсан тамирчинтай зөрж хоорондоо тоглож хожсон 2 тамирчин алт, мөнгөн медалийн төлөө, хожигдсон 2 тамирчин хүрэл медалийн төлөө тоглоно.
- 3.5.7. Тоглолт 3 үеэр 11 оноогоор явагдана. Эхний 2 үе дараалан хожсон тохиолдолд дахин тоглохгүй.
- 3.5.8. Хагас шигшээ болон шигшээ тоглолт 5 үеэр 11 оноогоор явагдана.

### **3.6. Волейбол**

- 3.6.1. Тэмцээнд оролцох багууд сугалаа сугалах журмаар 3 хэсэгт хуваагдана.
- 3.6.2. Хэсэгт хуваагдсан багууд дотроо тойргоор тоглож, хожлоороо шалгарсан эхний 2 баг дараагийн шатанд шалгарна. (Хэсгийн 1, 2-р байрыг шалгаруулахад хожил тэнцсэн тохиолдолд аль нэгнийгээ хожсон баг нь 1-ээр шалгарна. 3 баг бие биеэ тойрч хожин, нийт хожлын тоо тэнцсэн тохиолдолд тэдгээр багуудын хоорондын тоглолтын хожигдсон үеийг тоолж, аль цөөн үе хожигдсон "контр гаргаагүй" баг шалгарна)

- 3.6.3. Тоглолтын үе (Контр) тэнцвэл тухайн багуудын хоорондын тоглолтын нийт авсан оноо буюу бөмбөгнүүдийн нийлбэрийг нэмж аль их оноогоор хожсон баг дараагийн шатанд шалгарна. Хэсгээс шалгарсан багууд дахин бүсэд хуваагдан тоглож, бүс тус бүрээс 2 баг хагас шигшээд шалгарна.
- 3.6.4. Хагас шигшээд шалгарсан 4 багаас бүсээсээ 1-ээр гарсан баг нөгөө бүсээс 2-оор гарсан багтай зөрж, хоорондоо тоглож хожсон 2 баг алт, мөнгөн медалийн төлөө, хожигдсон 2 баг хүрэл медалийн төлөө тоглоно.
- 3.6.5. Тоглолт эрэгтэй 21, эмэгтэй 15 оноогоор явагдаж, хожил тэнцвэл нэмэлт үеийг 15 оноогоор явуулна.
- 3.6.6. Эхний 2 үе дараалан хожсон тохиолдолд дахин тоглохгүй.
- 3.6.7. Шигшээ тоглолтууд 21 оноогоор явагдаж, хожил тэнцвэл нэмэлт үеийг 15 оноогоор явуулна.

### **3.7. Сагсан бөмбөг**

- 3.7.1. Тэмцээнд оролцох багууд сугалаа сугалах журмаар 3 хэсэгт хуваагдана. Олон улсын сонирхогчдын сагсан бөмбөгийн дүрмээр шүүх ба сүүлийн 2 минут 24 секундийн зарчмаар явагдана.
- 3.7.2. Хэсэгт хуваагдсан багууд дотроо тойргоор тоглож, эхний 2 баг дараагийн шатанд шалгарна. (Хэсгийн 1, 2-р байрыг шалгаруулахад хожил тэнцсэн тохиолдолд аль нэгнийгээ хожсон баг нь 1-ээр шалгарна. 3 баг бие биеэ тойрч хожин, нийт хожлын тоо тэнцсэн тохиолдолд оноо тэнцсэн багуудын хоорондоо тоглосон тоглолтын онооны харьцаануудыг тоолж, аль их оноогоор хожсон баг дараагийн шатанд шалгарна)
- 3.7.3. Хэсгээс шалгарсан багууд дахин бүсэд хуваагдан тоглож, бүс тус бүрээс 2 баг хагас шигшээд шалгарна.
- 3.7.4. Хагас шигшээд шалгарсан 4 багаас бүсээсээ 1-ээр гарсан баг нөгөө бүсээс 2-оор гарсан багтай зөрж, хоорондоо тоглож хожсон 2 баг алт, мөнгөн медалийн төлөө, хожигдсон 2 баг хүрэл медалийн төлөө тоглоно.
- 3.7.5. Тоглолт 2 талдаа эрэгтэй бохир 8 минут, эмэгтэй бохир 6 минут байна. Торгуулийн шидэлтийн үед тоглолтын цагийг зогсооно. А, Б бүсээс хагас шигшээд шалгарсан 4 багийн тоглолтууд болон медалийн төлөөх тоглолтуудын үе бүрийн сүүлийн 2 минут цэврээр тоолно. Тоглолтын үндсэн цаг дуусахад оноо тэнцсэн тохиолдолд 3 минут сунгана.

### **ДӨРӨВ. ТЭМЦЭЭН ШҮҮХ ЖУРАМ**

- 4.1. Шүүгч нь тухайн спортын тэмцээнийг шүүх эрхтэй, ашиг сонирхлын зөрчилгүй, хөндлөнгийн шүүгч байна. Волейбол, сагсан бөмбөгийн тэмцээнийг үндсэн шүүгчээс гадна шугамын шүүгч шүүнэ.
- 4.2. Тэмцээн эхлэх үед 5 минутын дотор баг, тамирчид талбай дээр гарч ирээгүй тохиолдолд хожигдсонд тооцно.
- 4.3. Тоглолтын цаг, минут, зааварт заагдаагүй бусад асуудлыг техникийн зөвлөгөөн дээр эцэслэн шийдвэрлэнэ.
- 4.4. Тамирчид бие биедээ хүндэтгэлтэй хандаж, шүүгчийн шаардлагад захирагдах бөгөөд шүүгчийн гаргасан шийдвэрийг эсэргүүцсэн, маргаан үүсгэж бусдыг үл хүндэтгэсэн багийг тухайн тэмцээнээс хасна.
- 4.5. Тэмцээнтэй холбоотой гарсан аливаа маргааныг тэмцээнд оролцож буй багийн ахлагч, шүүгч нар зөвшилцөж шийдвэрлэнэ. Хэрэв шийдвэрлэх боломжгүй нөхцөл байдал үүссэн, санал тэнцсэн бол зохион байгуулагчид танилцуулж шийдвэрлүүлнэ.
- 4.6. Тамирчид санаатайгаар бие биедээ гэмтэл учруулах үйлдэл хийсэн тохиолдолд тухайн тамирчныг тоглолтоос хасна. Тэмцээний үр дүнг өөрчлөх, нөлөөлөх аливаа зохисгүй үйлдэл хийсэн тохиолдолд тухайн төрлийн тэмцээнээс хасна.
- 4.7. Тоглолтыг хуваарийн дагуу явуулна.
- 4.8. Тэмцээнд оролцох тамирчдын мэдүүлгийг Монголын хуульчдын холбооноос шалгах ба хуульчийн гэрчилгээгүй, хороонд харьяалагддаггүй тамирчинг тэмцээнд оруулсан тохиолдолд тухайн төрлийн тэмцээнээс багаар нь хасна.

## ТАВ.ТЭМЦЭЭН ДҮГНЭХ ЖУРАМ

- 5.1. Тэмцээний төрөл тус бүрт I, II, III байр шалгаруулж, багийн дүнг бага онооны системээр төрөл тус бүрт нэгтгэж, нийлбэр дүнгээр 1-3 байр эзлүүлэн шалгаруулна.
- 5.2. Тэмцээний нийлбэр дүнг гаргахдаа дараах байдлаар оноо өгч нэгтгэнэ.

### Ганцаарчилсан төрөл:

- 5.2.1.Усанд сэлэлт 2-8 оноо
- 5.2.2.Биллиард 2-8 оноо
- 5.2.3.Ширээний теннис 2-8 оноо

### Багийн төрөл:

- 5.2.4.Дартс 1-7 оноо
  - 5.2.5.Боулинг 1-7 оноо
  - 5.2.6.Волейбол 1-7 оноо.
  - 5.2.7.Сагсан бөмбөг 1-7 оноо
- 5.3.Багийн төрөлд 1-4 дүгээр байр эзэлсэн багуудад 1-4 оноо, ганцаарчилсан төрөлд 1-4 дүгээр байр эзэлсэн бол 2-5 оноо, бүсээс шалгарч хасагдсан бол багийн төрөлд 5 оноо, ганцаарчилсан төрөлд 6 оноо, хэсэгтээ 3-4 дүгээр байранд шалгарсан бол багийн төрөлд 6-7 оноо, ганцаарчилсан төрөлд 7-8 оноо тус тус авна.
  - 5.4.Тэмцээний ерөнхий шүүгч тоглолтын кодексыг гаргаж, тоглолтын хуваарийг хийн тэмцээний тоглолтын журмыг танилцуулж, баг тамирчдыг амжилтаар нь байр эзлүүлж, дүнг ерөнхий шүүгчид өгнө.
  - 5.5.Тэмцээнийг бага онооны системээр зохион байгуулж, онооны нийт дүнгээр, хэрэв багуудын нийлбэр оноо тэнцсэн тохиолдолд медалийн чанараар байр эзлүүлнэ.

## ЗУРГАА. ТЭМЦЭЭН ДҮГНЭХ ЖУРАМ

- 6.1. Тэмцээний төрөл бүр дээр I, II, III байр шалгаруулж, багийн дүнг төрөл тус бүрээр нэгтгэж, нийлбэр дүнгээр 3 байр эзлүүлэн шагнаж урамшуулна.
- 6.2. Тэмцээний төрөл тус бүрд  
**I байр:** Өргөмжлөл, алтан медаль, мөнгөн шагнал  
**II байр:** Өргөмжлөл, мөнгөн медаль, мөнгөн шагнал  
**III байр:** Өргөмжлөл, хүрэл медаль, мөнгөн шагнал олгоно.
- 6.3. Тэмцээнд оролцогч багуудын 7 төрлийн тэмцээний нийлбэр дүнгээр нь байр эзлүүлж, түрүүлсэн багт шилжин явах цом гардуулж, өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнах бөгөөд 2, 3-р байр эзэлсэн багт өргөмжлөл, мөнгөн шагнал олгоно.

## ДОЛОО.ТЕХНИКИЙН ЗӨВЛӨГӨӨН:

- 7.1.Тэмцээний техникийн зөвлөгөөн Хуульчдын холбооны фемида танхимд 2026 оны 05 дугаар сарын 08-ны өдөр 14:00 цагт болох бөгөөд тэмцээний төрөл тус бүрийг зохион байгуулах газар, өдөр, цагийг техникийн зөвлөгөөн дээр жич мэдэгдэнэ.
- 7.2.Тэмцээнд оролцох баг, тамирчид бооцооны мөнгө төлсөн баримт, тэмцээнд оролцох баг тамирчдын мэдүүлгийг Техникийн зөвлөгөөнд тухайн хорооны багийн ахлагч ирэхдээ авч ирнэ.
- 7.3.Техникийн зөвлөгөөн дээр тэмцээний төрөл тус бүрээр хэсэгт хуваагдах сугалааг зохион байгуулж, баг, тамирчдын оноолтыг хийнэ.
- 7.4.Техникийн зөвлөгөөний шийдвэр нь эцсийн шийдвэр байна.

## НАЙМ. БУСАД ЗҮЙЛ

- 8.1. Тэмцээний шагналын сан нь тэмцээнд оролцогч багуудаас төлөх хураамж хороо болгоноос 700,000 төгрөгөөс (бооцооны мөнгө) бүрдэнэ.
- 8.3. Тэмцээнд оролцох баг, тамирчид тэмцээнд оролцох баг тамирчдын мэдүүлгийг Техникийн зөвлөгөөнд тухайн хорооны багийн ахлагч ирэхдээ авч ирнэ.
- 8.4. Дартс, боулингийн тэмцээнд оролцох баг тамирчид нэг өнгийн жигд, сагсан бөмбөг, волейболын тэмцээнд оролцох баг тамирчид хувийн дугаар бүхий нэг өнгийн жигд хувцастай байна.
- 8.5. Тэмцээнтэй холбоотой хүсэлтийг багийн ахлагчаар уламжилж тэмцээний зохион байгуулалтын ерөнхий шүүгчид гаргана.

8.6.Төлбөр тушаах данс: Худалдаа хөгжлийн банк –MN07 0004 000 499218869 Хүлээн авагч:  
Монголын Хуульчдын холбоо

Гүйлгээний утга: Тэмцээний бооцооны мөнгө, Хорооны болон багийн нэр  
Холбоо барих: Зохион байгуулах ажлын хэсгийн гишүүн Т.Гүнбилэг /95800707/

---o0o---

